

Буцаж орж ирэх зөвшөөрөл чөлөөлөхийг түүдгэлзүүлэх болон урт хугацааны визтэй иргэд буцаж орж ирэхэд шинжилгээний бичиг өгөхтэй холбоотой мэдээлэл

А. Буцаж орж ирэх зөвшөөрөл чөлөөлөхийг түүдгэлзүүлэх болон буцаж орж ирэх зөвшөөрөл хүсэхтэй холбоотой мэдээлэл

- 2020оны бсарын 1ний өдрөөс эхлэн буцсаны дараа Солонгост буцаж орж ирэх гэж байгаа бүртгэлтэй гадаад иргэн «Цагаачлалын хяналтын тухай хууль» 30-р заалтын дагуу буцаж орж ирэх зөвшөөрөл авах хэрэгтэй бөгөөд буцаж орж ирэх зөвшөөрөл авахгүй гарсан тохиолдолд гадаад иргэний үнэмлэх хүчингүй болно.
- Харин, Дипломат албан хаагч (А-1), төрийн албан хаагч (А-2), Тохиролцоо (А-3) болон Гадаадын харьяат Солонгос үндэстэн (F-4) тус тус ангилалтай тохиолдолд буцаж орж ирэх зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд өмнөхтэй адил буцаж орж ирэхэд болно.
- Буцаж орж ирэх зөвшөөрлийг улсын хэмжээнд бүх гадаад иргэдийн харьяатын албанд хүсэлт гаргах боломжтой. (Нисэх буудал дээр ч гэсэн мэдэгдэх боломжтой)

Б. Буцаж орж ирэх урт хугацааны оршин суугч шинжилгээний бичиг өгөх тухай

- 2020оны бсарын 1ний өдрөөс эхлэн буцсаны дараа Солонгост эргэж орж ирэх бүртгэлтэй гадаад иргэд (Дипломат албан хаагч (А-1), Төрийн албан хаагч (А-2), Тохиролцоо (А-3), Гадаадын харьяат Солонгос үндэстэн (F-4) виз ангилал

хамрагдахгүй) байгаа газрынхаа буцах өдрөөс эхлэн 48цагийн доторх корона 19 шинжилгээ өгөн шинжилгээний хариу бичгийг биедээ авч орж ирнэ.

<Шинжилгээний бичигтэй холбоотой анхаарах зүйлс >

- Шинжилгээний бичгийг байгаа газрынхаа хүчинтэй эрүүл мэндийн байгууллагаас авах бөгөөд, англи хэл дээрх бичигл хүлээн зөвшөөрөгдөнө.

- Шинжилгээний бичиг дээр халуурах, ханиалгах, толгой өвдөх, амьсгалахад хэцүү, булчингийн өвдөлт, хатгалгаа зэрэг шинж тэмдэг байгаа эсэх болон шинжилгээ хийлгэсэн өдөр (Ирэх өдрийн өмнө 48цагийн доторх шинжилгээг хүлээн зөвшөөрнө), Шинжилгээг авсан хүн заавал бичигдсэн байна.

- Шинжилгээний бичигт COVID 19 сөрөг (Test Negative) эсэх нь заавал тусгагдах шаардлагагүй.

Харин, сөрөг эсэх нь тусгагдсан тохиолдолд хүчинтэй шинжилгээний бичигт тооцно.

- Шинжилгээ өгөөгүй болон хүчинтэй шинжилгээний бичиг байхгүй тохиолдолд, хуурамч өөрчилсөн бичиг болон худал хуурмаг бичиг өгсөн тохиолдолд онгоцонд суух болон орж ирэхийг татгалзах зэрэг эрсдэлийг хүлээх болно.

- Эсвэл, гадаад дахь дипломат төлөөлөгчийн газраас авсан хүчинтэй 'Тусгаарлахыг чөлөөлсөн бичиг' ийг биедээ авч яваа хүн шинжилгээний бичиг өгөөгүй ч гэсэн тусгай лан буцаж орж ирэх боломжтой.